



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ\*

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар A/282

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэний хүсэлтийг үндэслэн сумын Засаг даргын 2003 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн №44 тоот захирамжийн холбогдох заалтаар Нанзаддоржийн Цэрэндорж (ФМ53060172)-д Мөрөн сумын 1 дүгээр баг 17-8 тоот гэр бүлийн хэрэгцээний зориулалттайгаар эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээг 425м<sup>2</sup> гэснийг 567м<sup>2</sup> гэж өөрчилж үлдсэн 21 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2003 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн №44 тоот захирамжийн холбогдох заалтыг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч Н.Цэрэндорж (ФМ53060172)-той газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдэж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т, Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН